

# ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Эми Чой

2023 оны 4 дүгээр улирал



## МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн **Эми Чой** миний бие: (i) Компанийн тухай хууль (“КТХ”), Банкны тухай хууль (“БТХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: [2023 оны 4 дүгээр улирал] (“Тайлант хугацаа”).

### 1.ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

#### Тайлант хугацаан дахь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2023 оны 11 дүгээр сарын 01-06</li> <li>2023 оны 11 дүгээр сарын 30</li> <li>2023 оны 12 дугаар сарын 11-13</li> </ul>
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал (“АХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2023 оны 11 дүгээр сарын 29</li> </ul>
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал (“ЭУХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2023 оны 11 дүгээр сарын 29</li> </ul>
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшуулын хорооны хурал (“ЗНДЦУХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2023 оны 10 дугаар сарын 26</li> <li>2023 оны 11 дүгээр сарын 13</li> <li>2023 оны 11 дүгээр сарын 24</li> <li>2023 оны 11 дүгээр сарын 29</li> </ul>

#### 1.1 ТУЗ-ИЙН ХУРЛУУД

- **ТУЗ-ИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ** 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:
  - 1 ТУЗ-ийн өмнөх шийдвэр, зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл
  - 2 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:
    - 2.1 ЗНДЦУХ
    - 2.2 АХ
    - 2.3 ЭУХ
  - 3 2023 оны 10 дугаар сарын удирдлагын тайлан
    - 3.1 Эдийн засаг, банкны салбарын тайлан

**Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал**

- 3.2 Бизнесийн гүйцэтгэл
- 3.3 Санхүүгийн үр дүн
- 4 2024 оны төсөв, 2024 оны санхүүжилтийн төлөвлөгөө
- 5 Гүйцэтгэх захирлын 2024 оны ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт
- 6 [Redacted]
- 7 [Redacted]
- 8 [Redacted]
- 9 [Redacted]
- 10 [Redacted]
- 11 ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 01 сарын 12-ны өдөр зарлан хуралдуулах тухай (ногдол ашиг хуваарилах тухай болон бусад асуудлаар)
- 12 [Redacted]

Хэлэлцсэн асуудал #2.1 ЗНДЦУХ: ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох (ТУЗ-ийн гишүүд өөрсдийгөө улируулан сонгохоос бусад), Доминик Жакийг сонгох, дараагийн шатны жагсаалтад орсон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн талаарх явцын мэдээлэл болон хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцах ерөнхий журмыг тус бүр хэлэлцэж, эдгээр 3 асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр баталсан. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #2.2 АХ болон #2.3 ЭУХ: Тус 2 хорооноос ТУЗ-д хүргүүлсэн зөвлөмжүүдийг ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр баталсан. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #3 Удирдлагын тайлан: Би санхүүжилтийн стратеги ба хөрвөх чадварын эрсдэлийн талаар дахин саналаа хэлсэн.

Хэлэлцсэн асуудал #4 2024 оны төсөв, санхүүжилтийн төлөвлөгөө: Зээлийн хэмжээ хурдацтай өсөж байгаа ч харилцагчийн хадгаламжийн өсөлт салбарын жишигтэй харьцуулахад удаашралтай байгаа талаар санаа зовниж, саналаа хэлсэн. ТУЗ-ийн гишүүд харилцагчийн хадгаламжийн давуу болон сул талуудыг олон улсын санхүүжилтийн стратегитай харьцуулж дэлгэрэнгүй ярилцсан. ТУЗ санхүүжилтийн стратеги болон хөрвөх чадварын стресс тестийн тайланг дараагийн ТУЗ-ийн хурлаар нарийвчлан гаргахыг хүссэн. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #5 Гүйцэтгэх захирлын 2024 оны ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт: ТУЗ энэ асуудлыг нарийн хэлэлцэж, зарим үзүүлэлтүүдийн хувийн жинд бага зэрэг өөрчлөлт оруулсны дараа баталсан. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #6 [Redacted]

Хэлэлцсэн асуудал #7 [Redacted]

Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал

Хэлэлцсэн асуудал #10

Хэлэлцсэн асуудал #11 ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 01 сарын 12-ны өдөр зарлан хуралдуулах тухай: Монголбанкнаас холбогдох зөвшөөрөл авсны дараа санал хураалтыг явуулах нь зүйтэй гэдэгт ТУЗ-ийн гишүүд санал нэгдсэн. Дараа нь ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн цахим санал хураалтын хурлыг зарлаж, санал өгөхийг хүссэн ба ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй зөвшөөрсөн. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

• ТУЗ-ИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Хүснэгт 2-т заасан дараах ТУЗ-ийн цахим санал хураалтын хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь ТУЗ-ийн цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурал	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. ХасБанк ХК-ийн эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай; 2. ХасБанк ХК-ийн ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах тухай.	2023 оны 11 дүгээр сарын 01-06-ны өдөр
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. Банкны ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах болон хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”) -ыг эчнээ санал хураалт хэлбэрээр зарлан хуралдуулах тухай.	2023 оны 12 дугаар сарын 11-13-ны өдөр

Дээрх 3 асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэйгээр баталсан. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.2 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛ (“АХ”)

Хүснэгт 3-т заасан дараах АХ-ны хурлуудад оролцсон.

Тайлант хугацаан дахь АХ-ны хурлууд

Хүснэгт 3

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 11 дүгээр сарын 29	1. Жилийн эцсийн тойм/тайлангийн хурал 2. Монголбанкны газар дээрх шалгалтын урьдчилсан тайлан 3. Аудитын 2024 оны төлөвлөгөө, төсөв 4. Холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах 5. Аудитын тайлан

**Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал**

	5.1 Зээлийн хяналт 5.2 Үргэлжилсэн аудит 6. Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (МонголБанкны журам) 7. Шүгэл үлээхтэй холбогдох гарсан кейсүүдийн 2023 оны тайлан 8. Аудитын зөвлөмжийн эргэн хяналт
--	--

Хэлэлцсэн асуудал #1 Жилийн эцсийн тойм/тайлангийн хурал: Хувьцаагаа анх удаа олон нийтэд гаргасны (IPO) дараах анхны аудит учраас хүлээгдэж буй зээлийн алдагдал (ECL) болон холбогдох этгээдүүдийн зээл гэх мэт аудитын гол асуудлаас гадна удирдлагын баг болон ТУЗ-өөс анхаарах ёстой зүйл байгаа эсэхийг асуусан. Эрнст энд Янг Монголия (EY) үүнд хариулж, аудиторын хувьд нэмэлт тодруулга, шаардлага байхгүй ба санхүүгийн тайлангууд нь өмнөх тайлангуудтай ижил төстэй байна гэв.

Хэлэлцсэн асуудал #2 Монголбанкны газар дээрх шалгалтын урьдчилсан тайлан: Би Монголбанкнаас ямар нэгэн үнэлгээ өгсөн эсэхийг асуусан. Гүйцэтгэх захирал энэ нь урьдчилсан тайлан бөгөөд тайланг эцэслэн гаргахад л эцсийн үнэлгээ гарна гэж хариулав. Үнэлгээ гарсны дараа ТУЗ-д энэ талаар мэдээлэхээр болов.

Хэлэлцсэн асуудал #3 Аудитын 2024 оны төлөвлөгөө, төсөв: Шинэ аргачлалыг хэрэгжүүлэхэд одоогийн 17 хүний орон тоо хүрэлцэх боломжтой эсэхийг асуусан. Ерөнхий аудитор асуудал нь аудиторуудын тоонд биш харин шинэ аргачлалд ажиллах аудиторуудын ур чадварт байгаа гэж хариулсан.

Хэлэлцсэн асуудал #5 Зээлийн хяналтын аудитын тайлан: [REDACTED]

гэж дүгнэх нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн. Зээлийн хяналтын функц нь хамгаалалтын 2-р шугамын үр дүнтэй байдлын гол үзүүлэлт бөгөөд үүнийг сайжруулах шаардлагатай гэдгийг онцолсон. ТУЗ-ийн гишүүд өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлж, одоогийн зохион байгуулалт, үйл явцыг сайжруулах санал гаргасан. Гүйцэтгэх захирал өөрчлөлт хийх шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Хэлэлцсэн асуудал #8: Аудитын зөвлөмжийн эргэн хяналт: Дараагийн тайланд зөвлөмжийн дагуу “хэрэгжүүлж буй” гэж тэмдэглэсэн ажлуудын эцсийн хугацааг тогтоох мөн хугацаа хоцрогдолтой байгаа ажлуудад ямар арга хэмжээ авч байгааг тодорхойлохыг хүссэн.

Хэлэлцсэн асуудал #3 болон #4: ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр баталсан. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

**1.3 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЭУХ”)**

Хүснэгт 4-т заасан дараах ЭУХ-ны хурлуудад оролцсон.

Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал

Тайлант хугацаан дахь ЭУХ-ны хурлууд

Хүснэгт 4

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 11 дүгээр сарын 29	<ol style="list-style-type: none"> <li>2023 оны 10 дугаар сарын байдлаарх эрсдэлийн тайлан: Монголбанкны ангиллаарх байгууллагуудын зээлийн үлдэгдлийн тайлан 2023 оны чанаргүй зээлийн стратеги, дотоод үнэлгээ</li> <li>ХасБанкны 2024 оны стресс тест;</li> <li>Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл-жилийн тойм;</li> <li>2023 оны 10 дугаар сарын байдлаарх хянан нийцүүлэлтийн шинэчилсэн тайлан;</li> <li>Активыг тэнцлээс хасах санал;</li> <li>2023 оны 4 дүгээр улирлын холбогдох этгээд /сонирхлын зөрчлийн хэлцлийг соёрхон батлах;</li> <li>2023 онд банкны зээлийн удирдлагын хорооноос олгосон [redacted] зээлийн тойм.</li> </ol>

Хэлэлцсэн асуудал #1 Эрсдэлийн тайлан: Зээл хадгаламжийн харьцаа [redacted] болон Хөрвөх чадварын харьцаа [redacted]-ны талаар санаа зовниж, ЭУХ-ны дараагийн хурлаар хөрвөх чадвар болон санхүүжилтийн стратегийн талаар илүү нарийвчилсан дүн шинжилгээ хийж танилцуулахыг хүссэн.

Хэлэлцсэн асуудал #3 Хүлээн зөвшөөрөгдөх эрсдэл: Эрсдэл хариуцсан захирал зээл хадгаламжийн харьцааг [redacted] болгон өөрчлөх хүсэлтийг гаргасан. Би салбарын практикаас гажих, мөн ХасБанкны харилцагчийн итгэлд үзүүлэх нөлөөллийн талаар санаа зовниж, саналаа хэлсэн. Банкны хөрвөх чадвар, санхүүжилтийн стратегийн талаар өргөн хүрээтэй хэлэлцэж, ТУЗ-ийн хурлын 2024 оны төсвийг хэлэлцэх үед энэ асуудлыг дахин хэлэлцэхээр болсон.

Хэлэлцсэн асуудал #4 Хянан нийцүүлэлтийн явцын тайлан: Өндөр эрсдэлтэй харилцагч байгууллагуудыг цэгцлэхийн тулд урт хугацааны [redacted] үргэлжилсэн байдал дахин гарахаас хэрхэн сэргийлэх талаар асуусан. Эрсдэл хариуцсан захирал үүнийг өмнөх удирдлагын үеэс ужгирч үлдсэн асуудал бөгөөд цаашид дахин давтагдахгүй гэж хариулсан.

Хэлэлцсэн асуудал #5 болон #6: ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр баталсан. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

**1.4 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЗНДЦУХ”)**

Хүснэгт 5-т заасан дараах ЗНДЦУХ-ны хурлуудад оролцсон.

Тайлант хугацаан дахь ЗНДЦУХ-ны хурлууд

Хүснэгт 5

Огноо	Хэлэлцсэн асуудал
2023 оны 10 дугаар сарын 26 (ээлжит бус хурал)	1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл.

**Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал**

2023 оны 11 дүгээр сарын 13 (ээлжит бус хурал)	1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл.
2023 оны 11 дүгээр сарын 24 (ээлжит бус)	1. ХасБанкны Хараат бус гишүүний 1 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээлэл.
2023 оны 11 дүгээр сарын 29 (ээлжит хурал)	<ol style="list-style-type: none"> <li>1. ТУЗ-д ТУЗ-ийн гишүүдийг дахин сонгох [Доминик Жак болон Шинэ хараат бус гишүүнд нэр дэвшигчид нэмэгдэнэ] (2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас өмнө Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай);</li> <li>2. ХасБанкны хараат бус гишүүний нэг сул орон тоонд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтын явцын мэдээ;</li> <li>3. Хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөр (PSP) болон урт хугацааны урамшууллын төлөвлөгөө (LTIP)-ний дүн шинжилгээний ажлын хэсгийн явцын мэдээ;</li> <li>4. Хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцах ерөнхий журам;</li> <li>5. Залгамж халааны бодлого;</li> <li>6. Бусад.</li> </ol>

2023 оны 10-р сарын 26-ны өдрийн ЗНДЦУХ-ны ээлжит бус хурал, хэлэлцсэн асуудал 1: ЗНДЦУХ-ны 7-р сараас 10-р сар хүртэлх хугацаанд үргэлжилсэн эхний удаагийн сонгон шалгаруулалтаар улс төрд нөлөө бүхий этгээдийн болон сонирхлын зөрчлийн шалгуураар шүүж, мөн нэр дэвшигчидтэй хийсэн ярилцлагын дараа нийт 14 нэр дэвшигчээс 1 боломжит нэр дэвшигчийг дараагийн шатанд сонгосон. ЗНДЦУХ-ны 5 гишүүний 3 нь тус нэр дэвшигчийг дэмжсэн боловч саналын босго хувь болох 75 хувийн шаардлагыг хангаагүй учраас дэмжигдээгүй. Би тус нэр дэвшигчийг мэргэжлийн өндөр ур чадвартай, бусад ТУЗ-ийн гишүүдтэй сайн харьцах чадвартай гэж үзэж, дэмжсэн саналыг өгсөн.

2023 оны 11-р сарын 13-ны өдрийн ЗНДЦУХ-ны ээлжит бус хурал, хэлэлцсэн асуудал 1: ЗНДЦУХ-ны хоёр дахь удаагийн сонгон шалгаруулалт (энэ шатанд гадаад улсын харьяалалтай нэр дэвшигчдийг оролцуулахаар болсон)-д нийт 17 нэр дэвшигчээс 3 боломжит нэр дэвшигчийг дараагийн шатанд оруулахаар санал нэгдсэн. Сул орон тооны хараат бус гишүүнийг сонгох эцсийн хугацаа дуусч байсан тул ЗНДЦУХ-ны гишүүд дараагийн 1-2 долоо хоногийн дотор тэдгээр 3 боломжит нэр дэвшигчтэй ярилцлага хийхээр болсон.

2023 оны 11-р сарын 24-ний өдрийн ЗНДЦУХ-ны ээлжит бус хурал, хэлэлцсэн асуудал 1: Би тус хуралд оролцсон боловч 3 боломжит нэр дэвшигчид санал өгч, шийдвэрлэхэд ЗНДЦУХ-ны хангалттай ирц хүрээгүй. Уг асуудлыг 11-р сарын 29-нд болох ЗНДЦУХ-ны ээлжит хурлаар хэлэлцэхээр хойшлуулав.

2023 оны 11-р сарын 29-ний өдрийн ЗНДЦУХ-ны хурал:

- Хэлэлцсэн асуудал #1 болон #4: Тус тайлангийн ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын #2.1-т энэ тухай бичсэн байгааг харна уу.
- Хэлэлцсэн асуудал #2: Дараагийн шатанд орсон 3 боломжит нэр дэвшигчийг хорооны гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал

- Хэлэлцсэн асуудал #5: Залгамж халааны бодлого: ХасБанкинд чухал үүрэг гүйцэтгэдэг өсөх ирээдүйтэй гэж тодорхойлсон хүний нөөцийн “Давуу тал /Сул тал/Хөгжлийн төлөвлөгөө”-ны мэдээлэл дутуу байгаа тухай хэлсэн. Би Гүйцэтгэх захирлаас залгамж халааны бодлогод дутуу байгаа мэдээллийг нэмж оруулахыг хүссэн.

**2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН**

**(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)**

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд, ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар нийт **3 (гурв)** сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан. Эдгээр бүх хэлцэлд оролцож, саналаа өгч ажилласан. Надад хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

**3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН**

**(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)**

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалыг дүгнэхэд:

<b>КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ</b>	
<p><b>КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5</b></p> <p><b>(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)</b></p>	<p>ТУЗ болон удирдлагын баг хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргаж, нарийн зүйлүүдийг анхаарч авч үздэгийг ажигласан. Ялангуяа IPO хийсний дараах эргэн хяналт, ТСН-ийг ХасБанктай нэгтгэх мөн 4 дэх хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын үйл явцад анхаарлаа хандуулан ажилласан.</p>
<p><b>КтХ 79.3.2</b></p>	<p>ТУЗ болон удирдлагын баг үүргээ хангалттай хэмжээнд ил тод гүйцэтгэж байгааг би ажигласан. Анхаарал татахуйц ямар нэгэн асуудал ажиглагдаагүй.</p>



**Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал**

<b>(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)</b>	
<b>КтХ 79.3.3  (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ)</b>	Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаагүй болно.
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1  (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)</b>	ТУЗ болон удирдлагын багийн гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт нийцэж байгааг ажигласан.
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2  (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)</b>	ТУЗ болон удирдлагын баг бүх цаг үед холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, хичээн ажиллаж байсныг ажигласан.
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3  (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)</b>	ТУЗ болон удирдлагын зүгээс банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн аливаа үйлдэл, шийдвэр гаргаагүй.

**Хараат бус гишүүний тайлан-4 дүгээр улирал**

<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6</b>  <b>(МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)</b>	Мэдээлэх ямар ч асуудал ажиглагдаагүй болно.
---	--

**4. БУСАД**

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ТУЗ-ийн хүлээн авалтын оройн зоогт оролцсон. Энэ удаа гүйцэтгэх удирдлагын багаас гадна дунд шатны удирдлагын баг мөн оролцсон. Уулзалтын үеэр миний анзаарсан сайн зүйл бол ажилтнууд банкны өнгөрсөн жилүүдийн санхүүгийн сайн үр дүн, үзүүлэлтэд маш эергээр хандаж, Гүйцэтгэх захирал ба гүйцэтгэх удирдлагуудад сэтгэл хангалуун байсан. Мөн Гүйцэтгэх захирлын анхаарлаа хандуулах чухал зүйл бол салбарын асуудал болж буй хүний нөөцийн эргэлтийн түвшин өндөр байгаа явдал юм.

2023 оны 12 дугаар сарын 02-ны өдөр банкны түнш болох "Хөгжлийн Шийдэл" Төрийн бус байгууллага ("ТББ")-ын үйл ажиллагаатай танилцсан. Тус ТББ нь жижиг дунд үйлдвэр ("ЖДҮ") эрхлэгчдэд зориулж бизнес эрхлэх, санхүүгийн зээлийн өргөдөл гаргах чиглэлээр сургалт явуулж, гарааны бизнесээ эхлүүлэхэд нь тусалдаг. ЖДҮ нь Монгол улсын нийт ажиллах хүчний 57%-ийг ажилтай болгоход хувь нэмрээ оруулж, ДНБ-ий 17%-ийг бүрдүүлж байна. Тус түнш нь ХасБанкны түргэн шуурхай, мэргэжлийн үйлчилгээний талаар өндөр үнэлгээ өгсөн. Би ХасБанк нийгмийн хариуцлагын хүрээнд ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн сургалт хийх нь илүү үр дүнтэй талаар Гүйцэтгэх захиралд саналаа хэлсэн.

Огноо: 2024 оны 01 дүгээр сарын 02

Гарын үсэг: Эми Чой